



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 306

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө худалдах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын бүртгэлтэй, ашиглах боломжгүй нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 35,074,826.00 (гучин таван сая далан дөрвөн мянга найман зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2."Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Цагаанхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн омчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн  
2018 дугаар тогтоолын хавсралт

"РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ" УТУГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

| Д/д | Автомашины нэр, марк, улсын бүртгэл, арлын дугаар | Үйлдвэрлэсэн он, ашиглалтад орсон он | Нийт гүйлт (км) | Балансын нийт үнэ (төгрөг)                                     | Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)                                | Үлдээдэл өртөг (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг) |
|-----|---|--------------------------------------|-----------------|--|--|-------------------------|----------------------------|
| 1   | Тойота камри, 01-11 УНЦ (арал-4t4be46k98r044630)  | 2008/2011                            | 66406           | 35,074,826.00  | 35,074,826.00  | -                       | 4,000,000.00               |
|     | Нийт дун  |                                      |                 | (гучин таван сая далан дөрвөн мянга найман зуун хорин зургаан) | (гучин таван сая далан дөрвөн мянга найман зуун хорин зургаан) |                         | 4,000,000.00 (дөрвөн сая)  |